**ОРХОН АЙМГИЙН ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗАР**

# ШИНЭ ХӨДӨӨ ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ, ХЭРЭГЦЭЭ ШААРДАЛАГА, ЗАРЦУУЛАЛТ, АШИГЛАЛТ, ҮР ДҮН

ОАХХААГ-2024/01/-05

**Хөрөнгийн зарцуулалтад зарим холбогдох хууль тогтоомжийг мөрдөж ажиллаагүй, санхүүгийн бүртгэл хөтлөлт, анхан шатны баримт бүрдүүлэлт хангалтгүй байна.**




**Орхон аймаг**
**2024 он**

# Агуулга

**Аудитыг гүйцэтгэсэн:**

Орхон аймаг Хүнс, хөдөө аж ахуйн газрын хяналт-шинжилгээ үнэлгээ, дотоод аудит хариуцсан мэргэжилтэн
Б.Батжаргал

2024 оны 08 сарын 26-ны өдрөөс 10 дугаар сарын 07-ны өдөр хүртэл

Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 94209421 утсаар харилцана уу.

Уг тайланг ХХААГ-ын веб сайтаас үзнэ үү.

https://hhaag.erdenet.mn/


Товчилсон үгийн тайлбар 1

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, шалгуур үзүүлэлт, аудит хийх үндэслэл. 2

Үндсэн мэдээлэл 3

**БҮЛЭГ 1. Шинэ хөдөө төсөл хэрэгжүүлэх үндэслэл, хэрэгцээ шаардлага**

1.1 Төсвийн тухай хуулийн дагуу төсөв хэлэлцэх үед ил тод мэдээлээгүй, судалгаа хийгдээгүй, хэрэгцээ шаардлагыг тодорхойлоогүй байна. 5

**БҮЛЭГ.2 Шинэ хөдөө төслийн явц, хэрэгжилтийн байдал, бүртгэл хөтлөлт, зах зээлийн үнэ, өртөг, сонгон шалгаруулалт, ашиглалт, ил тод байдал, болзошгүй эрсдэл.**

2.1 Шинэ хөдөө төслийн хөрөнгөөр ТАХ хэрэгжүүлэхдээ холбогдох хууль тогтоомжийн зарим заалтыг зөрчсөн байна. 6

2.1.1 Төслийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг хуулийн зарим заалтуудыг зөрчин зохион байгуулсан байна. 6

2.2 Шинэ хөдөө төслөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний үр дүнд бий болсон зарим хөрөнгө ашиглалтын шаардлага хангахгүй байна. 7

2.3 Шинэ хөдөө төслийн бүртгэл хөтлөлт, санхүүгийн анхан шатны баримтын бүрдүүлэлт хангалтгүй байна. 7

2.4 Ил тод байдал хангалтгүй байна.

2.4.1 Шинэ хөдөө төслийн ил тод байдал хангалтгүй байгаагаас төсөл ирүүлээгүй аж ахуйн нэгж байгууллагууд тоног төхөөрөмжийн хөнгөлөлтөд хамрагдаж сонгон шалгаруулах ажлын хэсэг байгуулж ажиллуулсан үр дүнгүй байна. 14

2.4.2 Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээлсэн байдал. 16

2.5 Шинэ хөдөө төслийн тоног төхөөрөмжийг эзэмшүүлэх сонгон шалгаруулалтын үйл ажиллагаа хангалтгүй байна. 16

2.5.1 Сонгон шалгаруулалтыг хугацаа алдаж зохион байгуулсан, сонгон шалгаруулалтын процесс алдагдсан байна.

2.5.2 Сонгон шалгаруулалтаар 1 аж ахуйн нэгжид олон тоног төхөөрөмж олгох, гадны аймгаас хамрагдах зэргээр аймгийн жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн боломж, хүртээмжид сөргөөр нөлөөлж байна. 19

2.6 Төслийн явц, хэрэгжилтийн байдал, ашиглалтын байдалд дүн шинжилгээ хийхэд 25 хувь нь ашиглаагүй. Энэ нь сонгон шалгаруулалтын шийдвэр оновчгүй байгааг харуулж байна. 19

2.6.1 Үйлдвэрлэгч баг, Шинэ хөдөө төслийн хэрэгжилтийн байдал, зарим тоног төхөөрөмж олгогдож, гэрээ байгуулагдаагүй байна. 19

| | |
|---|---|
| 2.6.2 Төслийн тоног төхөөрөмжийг түүврийн аргаар ашиглалтын байдалтай газар дээр нь очиж танилцахад 25 хувь нь ашиглаагүй, зарим тоног төхөөрөмж суурилуулсан, сэлбэг хэрэгсэл авах болон тохируулгын шатанд байна. | 31 |
| 2.6.3 Шинэ хөдөө төслөөр хэрэгжсэн тоног төхөөрөмж нь ирээдүйд орон нутгийн хөгжилд хувь нэмрээ оруулахаар байна. | 34 |
| **БҮЛЭГ.3 Төслийн үр дүн тооцох, дүгнэлт, зөвлөмж, санал боловсруулах** | |
| Дүгнэлт | 37 |
| Зөвлөмж | 39 |
| Дотоод хяналт хэрэгжүүлсэн мэргэжилтний санал | 40 |

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

| | |
|---|---|
| ААНБ | Аж ахуйн нэгж байгууллага |
| ХХААХҮС | Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд |
| ШУТИС | Шинжлэх ухаан техникийн их сургууль |
| ХАА | Хөдөө аж ахуй |
| ХХААХҮЯ | Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам |
| ЗДТГ | Засаг даргын Тамгын газар |
| ИТХ | Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал |
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| МУ | Монгол улс |
| НББ | Нягтлан бодох бүртгэл |
| ХХК | Хязгаарлагдмал хариуцлагатай компани |
| ШШГГ | Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар |
| ХААМСҮТ | Хөдөө аж ахуйн мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв |
| ХХААГ | Хүнс, хөдөө аж ахуйн газар |
| БМО | Бараа материалын орлого /маягт/ |
| УТ | Улсын төсөв |
| УИХ | Улсын Их Хурал |
| НББББ | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг |
| ТАХ | Төсөл арга хэмжээ |
| ХХҮГ | Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар |
| ЭШУТП | Эрдэнэт шинжлэх ухаан технологийн парк |

**Дотоод аудит хийх үндэслэл, эрх зүй:**

Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5.2 дахь хэсэг, Хүнс, хөдөө аж ахуйн газрын дотоод хяналт шалгалт зохион байгуулах журам, байгууллагын дотоод аудит хийх 2024 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах хүрээнд "Шинэ хөдөө" төслийн холбогдох хууль, дүрэм, журмын хэрэгжилт, сонгон шалгаруулалт, ил тод байдал, бүртгэл хөтлөлт, ашиглалт, технологит ажил, хяналт, үнийн хөнгөлөлт, үр дүн зэрэг үзүүлэлтээр хяналт-шинжилгээ үнэлгээ хийж, дүгнэлт, зөвлөмж гаргах, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал боловсруулахад туслах, эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд дотоод аудитын зорилго оршино.

**Дотоод аудитын зорилт:**

Шинэ хөдөө төслийг хэрэгжүүлэх үндэслэл, хэрэгцээ шаардлага, үнэ, хөрөнгийн зарцуулалтад хууль тогтоомжид нийцсэн эсэхэд аудит хийж, дүгнэлт, зөвлөмж, санал боловсруулан дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх, засаж залруулахад дотоод хяналтын зорилт чиглэгдлээ.

Дээрх зорилтыг хангахын тулд аудитыг дараах дэд зорилтын хүрээнд гүйцэтгэлээ. Үүнд:

- Холбогдох хууль эрх зүйн хэрэгжилт, төслийн хэрэгжүүлэх үндэслэл, хэрэгцээ шаардлагыг тодорхойлсон эсэх
- Шинэ хөдөө төслийн явц, хэрэгжилтийн байдал, бүртгэл хөтлөлт, зах зээлийн үнэ, өртөг, сонгон шалгаруулалт, ашиглалт, ил тод байдал, болзошгүй эрсдэл зэрэгт хяналт шинжилгээ, үнэлгээ хийх,
- Төслийн үр дүн тооцох, дүгнэлт, зөвлөмж, санал боловсруулах

**Дотоод аудитын хамарсан хүрээ:**

Хүнс, хөдөө аж ахуйн газар болон аймаг, сумдын ЗДТГ-ыг хамрууллаа.

**Дотоод аудитын арга зүй:**

Монгол Улсын холбогдох хууль, журам, тушаал шийдвэрийг үндэслэл болгон хяналт шалгалтад хамаарах барим бичиг, гэрээгээр эзэмшиж, ашиглаж байгаа иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас асуулга лавлагаа, тодруулга авах, тоног төхөөрөмж, техник хэрэгслийг үзэх, харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглан нотлох зүйл цуглуулж, гарсан зөрчлийн уялдаа холбоог тогтоох, арилгах зөвлөмж, санал боловсруулллаа.

**Дотоод аудитад ашигласан шалгуур үзүүлэлтүүд:**

Дотоод аудитын арга зүйтэй холбоотой дараах хууль, эрх зүйн актын холбогдох заалтыг шалгуур үзүүлэлт болгон ашиглав. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Монгол улсын 2022-2024 оны хөгжлийн жилийн төлөвлөгөө
- Нийтийн мэдээллийн ил тод байдлыг хангах тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль;
- УСНББОУС
- Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа төсөвт байгууллагад мөрдөх НБББББ
- Төрийн хяналт шалгалтын тухай хууль
- Хүнс, хөдөө аж ахуйн газрын дотоод хяналт шалгалт зохион байгуулах журам
- Байгууллагын дотоод аудит хийх 2024 оны төлөвлөгөө

**Дотоод аудит хийж гүйцэтгэсэн:**

Орхон аймаг Хүнс, хөдөө аж ахуйн газрын хяналт-шинжилгээ үнэлгээ, дотоод аудит хариуцсан мэргэжилтэн Б.Батжаргал газрын даргын 01 тоот удирдамжийн дагуу хийж гүйцэтгэв.

**Дотоод аудитыг гүйцэтгэсэн хугацаа:**

Дотоод аудитын ажлыг 2024 оны 08 дугаар сарын 26-ны өдрөөс, тайлагналын үе шатны ажлыг 09 дүгээр сарын 20-ны өдрөөс эхлэн, тайланг 2024 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн дотор үе шатны газрын даргын хяналтаар оруулж, хэлэлцүүлэн 2024 оны 10 дугаар сарын 24-ний өдөр баталгаажуулж, 2024 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн дотор холбогдох газарт зөвлөмжийг хүргүүллээ.

**Үндсэн мэдээлэл:**

МУ-ын 2023 оны төсвийн тухай хуулиар ХХААХҮС-ын багцад нийт 3,500.0 сая төгрөг батлагдсан.

/сая төгрөгөөр/

| Хуулийн дугаар | Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил | Хугацаа | | Төсөвт өртөг | Санхүүжих дүн |
|---|---|---|---|---|---|
| XVII.3.7 | Бизнес эрхлэгчдийг дэмжих "Смарт ээзд" хөтөлбөр /Орхон/ | 2022 | 2022 | 800.0 | 800.0 |
| XVII.3.16 | Олон талт түншлэлийн хүрээнд "Үйлдвэрлэгч баг" төсөл /Орхон, Баян-Өндөр сум/ | 2022 | 2023 | 2,500.0 | 1,000.0 |
| XVII.3.18 | Орон нутгийн үйлдвэрлэлийг дэмжих тоног төхөөрөмж /Орхон/ | 2022 | 2022 | 200.0 | 200.0 |

МУ-ын 2023 оны төсвийн тухай хуулиар Үйлдвэрлэгч баг төсөлд 1,470.0 сая төгрөг батлагдсан.

/сая төгрөгөөр/

| Хуулийн дугаар | Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил | Хугацаа | | Төсөвт өртөг | Санхүүжих дүн |
|---|---|---|---|---|---|
| XIII.3.6 | Олон талт түншлэлийн хүрээнд "Үйлдвэрлэгч баг" төсөл /Орхон, Баян-Өндөр сум/ | 2022 | 2023 | 2,470.0 | 1,470.0 |
| XIII.3.3 | Орон нутгийн хөгжлийг дэмжих "Шинэ хөдөө" төсөл /Баянхонгор, Булган, Говьсүмбэр, Дархан-Уул, Дорноговь, Дундговь, Сүхбаатар, Сэлэнгэ, Орхон, Төв, Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, Ховд, Хөвсгөл/ | 2022 | 2023 | 12,114.8 | 11,767.8 |

МУ-ын 2024 оны төсвийн тухай хуулиар Шинэ хөдөө төсөлд нийт 4,020.0 сая төгрөг батлагдсан.

/сая төгрөгөөр/

| Хуулийн дугаар | Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил | Төслийн код | Эхлэх | Дуусах | 2024 оны төсөвт өртөг | Санхүүжих дүн | Эх үүсвэр |
|---|---|---|---|---|---|---|---|
| XVIII.3.7 | "Шинэ хөдөө-хүлэмж" төслийн тоног төхөөрөмж /Орхон, Жаргалант сум/ | УТ2401900399 | 2024 | 2024 | 500.0 | 500.0 | Улсын төсөв |
| XVIII.3.8 | "Шинэ хөдөө-үйлдвэрлэгч өрх" төслийн тоног төхөөрөмж /Орхон, Жаргалант сум/ | УТ2401900400 | 2024 | 2024 | 500.0 | 500.0 | Улсын төсөв |
| XVIII.3.9 | Бичил бизнес эрхлэгчдийг дэмжих тоног төхөөрөмж /Орхон, Баян-Өндөр сум/ | УТ2401900396 | 2024 | 2024 | 2,200.0 | 2,200.0 | Улсын төсөв |
| XVIII.3.27 | Орон нутгийн хөгжлийг дэмжих "Шинэ хөдөө" төсөл /Орхон/ | УТ2401900395 | 2024 | 2024 | 820.0 | 820.0 | Улсын төсөв |

ОРХОН АЙМГИЙН ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗАР

**Шинэ хөдөө төслийн хөрөнгийг хууль, журмын дагуу үр дүн, үр нөлөөтэй хэрэгжүүлсэн эсэх:**

# Бүлэг 1 ШИНЭ ХӨДӨӨ ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮНДЭСЛЭЛ, ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГА

**2022 онд судалгаа, шинжилгээ хийж үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж, хүлэмжийн аж ахуйг хөгжүүлснээр өрхийн орлого нэмэгдэх, өрхийн тариалан эрхлэгчдийн техник, тоног төхөөрөмжийн чадавхыг сайжруулж бараа бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлэх, эдийн засгийн эргэлтэд оруулах боломжтойг тодорхойлсон ч Төсвийн тухай хуулийн дагуу төсөв хэлэлцэх үед ил тод мэдээлээгүй, судалгаа хийгдээгүй, хэрэгцээ шаардлагыг тодорхойлоогүй байна.**

Төсвийн тухай хуулиар 281.2.4. ”Төсвийн төслийг боловсруулахад ашигласан тоон мэдээлэл, судалгаа, аргачлал нь олон нийтэд нээлттэй байж, санал өгөх боломжтой байх” заалттай бөгөөд энэхүү заалтыг хэрэгжүүлээгүй, судалгаа хийгдээгүй байна. Орхон аймгийн ЗДТГ-аас иргүүлсэн захиалгын дагуу “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ, ШУТИС-ийн харьяа, Шагдарын Отгонбилэгийн нэрэмжит “Эрдэнэт цогцолбор дээд сургууль”-ийн багш А.Батдаваа, З.Баттуяа нар 2022 оны 10 дугаар сард “Орхон аймгийн ХАА-н салбарт нөлөөлөгч хүчин зүйлийн судалгаа, үр дүн” тэр дундаа Орхон аймгийн газар тариалангийн салбарт нөлөөлж буй хүчин зүйлсийг асуулгын аргаар үнэлсэн.

Судалгаанд оролцогчдын 64.9% нь (1-5) хүртэлх ажиллах хүчинтэй байгаа нь өрхийн гэр бүлийн хүрээнд аж ахуйг эрхлэх хандлага давамгайлж байна. Газар тариалангийн салбар нь улирлын чанартай, ажиллагсад нь түр ажилтан эсвэл өрхийн гишүүдийн оролцоо дэмжлэгээр үйл ажиллагаа явагддаг. Аж ахуй эрхэлсэн туршлагаас үзэхэд 55.8% нь 15-дээш жил ажилласан туршлагатай гэсэн хэдий ч Газар тариалангийн салбарт нөлөөлөгч 28 хүчин зүйлсийг судалгаанд оролцогчдоор Лайкерт шкалын аргаар үнэлсэн бөгөөд “Олон улсын болон төрийн бус байгууллагуудын оролцоо дэмжлэг” гэсэн хүчин зүйл нь тариаланчдаас маш муу үнэлгээ авсан нь ХАА-н салбарт үйл ажиллагаа явуулж буй төрийн бус байгууллагуудын хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөрүүд тариаланч ногоочдод өгөөжгүй байдаг нь судалгаанаас харагдаж байна гэж дүгнээд  Төсөл хөтөлбөр, хөрөнгө оруулалтууд нь яг малчин, тариаланчдад хүрч байна уу гэдэгт цаашид маш хатуу хяналт тавь ажиллах шаардлагатай байна.

- Өрхийн аж ахуйн чадамжийг дээшлүүлэх,
- Урт хугацаатай эргэлтийн хөрөнгийн санхүүжилтийн нөхцөлийг бий болгох,

• Өрхийн тариаланчдын техник тоног төхөөрөмжийн чадавх муу байгаа тул урт хугацаатай хөнгөлөлтэй зээлийн санхүүжилтээр шийдэх,

• Зоорины хүрэлцээг шийдэх,

• Ногоочдын худаг ус, усалгааны системийг сайжруулах,

• Борлуулалтын тогтмол нийлүүлэгчдийн сувгийг бий болгож тариаланч, борлуулагчдын хоорондын уялдаа холбоог хангаж өгөх,

• Ногоочдын ХАА-н техник тоног төхөөрөмжийн чадамжийг сайжруулах үүднээс хөнгөлөлтэй зээлийн санхүүжилтийн төсөл хөтөлбөрөөр шийдэх зэрэг санал, зөвлөмж өгсөн байна.

2022 оны төсвийн төсөл, хэлэлцүүлгийн үе шат, нээлттэй байдлыг судлахад Шинэ хөдөө төслийн суурь судалгаа хийгээгүй, хэрэгцээ шаардлагаа үнэлээгүй, олон нийтэд төсөл хэрэгжүүлэх талаар санал аваагүй, ил тод нээлттэй бус, төсөв батлагдсаны дараа аймгийн ЗДТГ-аас судалгаа зохион байгуулсан зэрэг асуудлууд байна.

**ОРХОН АЙМГИЙН ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗАР**

**Шинэ хөдөө төслийн хөрөнгийг хууль, журмын дагуу үр дүн, үр нөлөөтэй хэрэгжүүлсэн эсэх:**

# Бүлэг 2 ШИНЭ ХӨДӨӨ ТӨСЛИЙН ЯВЦ, ХЭРЭГЖИЛТИЙН БАЙДАЛ, БҮРТГЭЛ ХӨТЛӨЛТ, ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭ, ӨРТӨГ, СОНГОН ШАЛГАРУУЛАЛТ, АШИГЛАЛТ, ИЛ ТОД БАЙДАЛ, БОЛЗОШГҮЙ ЭРСДЭЛ

## 2.1 Шинэ хөдөө төслийн хөрөнгөөр ТАХ хэрэгжүүлэхдээ холбогдох хууль тогтоомжийн зарим заалтыг зөрчсөн байна.

### 2.1.1 Төслийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагаа хуулийн зарим заалтуудыг зөрчин зохион байгуулсан байна.

ХХААХҮС-ын 2022 оны  02 дугаар сарын 21-ний өдрийн А/58 дугаар “Зарим хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний эрх шилжүүлэх хуваарь шинэчлэн батлах тухай” тушаалаар Орхон аймагт 1. Бизнес эрхлэгчдийг дэмжих “Смарт ээд” хөтөлбөр 800,000,000 төгрөг, 2. Олон талт түншлэлийн хүрээнд “Үйлдвэрлэгч баг” төсөл 2,500,000,000 төгрөгийн төсөвт өртгөөс санхүүжих дүн 1,000,000,000 төгрөг, Орон нутгийн үйлдвэрлэлийг дэмжих тоног төхөөрөмж 200,000,000 төгрөгийн шийдвэр гаргасан байна.

https://www.tender.gov.mn/mn/invitation/detail/1638948443452 хаягаар Олон талт түншлэлийн хүрээнд "Үйлдвэрлэгч баг" төсөл /Орхон, Баян-Өндөр сум/ 2022-01-28 ны өдөр нээлттэй тендер зарлаж,

1. " Хүлэмж " 1,500,000,000₮
2. " Үйлдвэрийн тоног төхөөрөмж, техник хэрэгсэл " 1,000,000,000₮

Тендерийг 2022 оны 01 дүгээр сарын 28-ны өдөр зарлаж, урилга өгөхдөө зах зээлийн судалгаа хийгээгүй нэг бүрийн үнийг 10,000,000 төгрөгөөр зарлажээ. Тус тендерт Сэхүүн чоно ХХК шалгарч нэгжийн үнэ 9,933,333 төгрөгийн санал ирүүлж, 10,000,000 төгрөгөөр 6*20 метрийн 60ш хүлэмж нийлүүлэгдсэн байна. 2022 оны 03 дугаар сарын 30-ны өдөр Сэхүүн чоно ХХК-тай Үйлдвэрлэгч баг төслийн хүрээнд 2022 онд 1,000,000,000 төгрөг, 2023 онд 1,470,000,000 төгрөгийн худалдан авах №ХХААХҮЯ/202212056 дугаар гэрээ байгуулсан байна.

2023 онд 10 ширхэг хүлэмжийн гэрээг Мөнх ногоон тал ХХК-тай ХХААХҮЯ-ний төрийн нарийн бичгийн дарга байгуулж, эрх олгон нийлүүлжээ. 2022 оны хүлэмжийн техникийн тодорхойлолт, тавигдах шаардлага ижил бөгөөд нэг бүрийн үнийг 6,150,000 төгрөг буюу өмнөх оны мөнгөн дүнгээс 3,850,000 төгрөгөөр бага нийлүүлэгджээ.

**2.2 Шинэ хөдөө төслөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний үр дүнд бий болсон зарим хөрөнгө ашиглалтын шаардлага хангахгүй байна.**

Сэхүүн чоно ХХК-аас 2022, 2023 онуудад 150ш Хятад улсад үйлдвэрлэсэн хүлэмжийг 10,000,000 төгрөгөөр нийлүүлсэн. 2023 онд ХХААХҮЯ нь Мөнх ногоон тал ХХК-тай гэрээ хийж 10ш хүлэмжийг нэг бүрийг үнэ 6,150,000 төгрөгөөр Солонгос улсад үйлдвэрлэсэн хүлэмж нийлүүлсэн байна. Нэг бүрийн үнээс 3,850,000 төгрөгийн хямд бөгөөд чанартай. Сэхүүн чоно ХХК нь Солонгос улсад үйлдвэрлэсэн хүлэмж нийлүүлсэн бол чанартайгаас гадна 577,500,000 төгрөг хэмнэх байжээ.

**2.3 Шинэ хөдөө төслийн бүртгэл хөтлөлт, санхүүгийн анхан шатны баримтын бүрдүүлэлт хангалтгүй байна.**

2022 оны 06 дугаар сарын 06-ны өдөр аймгийн Засаг даргын 2022 оны А/120 дугаар захирамжаар байгуулсан ажлын хэсэг нь хүлэмжийн аж ахуй эрхэлдэг 60 иргэнд хүлэмж олгох, батламж гардуулж, цаашид гэрээ байгуулах, хүлэмжийг ашиглах зөвлөмж өгсөн байна. Баян-Өндөр сумын 49 иргэн, Жаргалант сумын 11 иргэнд иж бүрэн хүлэмжийг хөрөнгө хүлээлцэх актаар баталгаажуулан олгожээ.

## ЗУНЫ НИЙЛЭГ ХАЛЬСАН ХҮЛЭМЖИЙГ ГЭРЭЭГЭЭР ЭЗЭМШҮҮЛЭХ ИРГЭДИЙН НЭРСИЙН ЖАГСААЛТ

2022.06.06

Орхон аймаг

| № | Овог нэр | Регистрийн дугаар | Гэрийн хаяг | Утасны дугаар | Гарын үсэг |
|---|---|---|---|---|---|
| 1. | Гомбо Энхжаргал | АИ73122809 | БӨ-ц/чулуут 9-7 | 99319226 | |
| 2. | Батчулуун Батэрдэнэ | ФБ79080319 | БӨ овоот 4-1 | 95455777 | |
| 3. | Цэрэнсэрээтэр Ганбат | ЕТ53070811 | БӨ-говил7-14 | 99222424 | |
| 4. | Готов Пүрэвдорж | ФБ64091219 | БӨ-яргуйт 13-33 | 99365999 | |
| 5. | Батменх Уянга | ГЮ78101707 | БӨ-дэнж 10-42 | 94352020 | |
| 6. | Банзар Машлай | ФБ42051011 | БӨ-наран 30-8 | 91359466 | |
| 7. | Болдбаатар Болортуяа | МХ89091701 | БӨ-эрдэнэ 18-26 | 88080917 | |
| 8. | Бямбажав Батчимэг | ГБ65030109 | БӨ-шанд 41-19 | 99550034 | |
| 9. | Жамба Цэрэнсодном | ДЮ69111064 | БӨ-зүүн дэнж 4-15 | 80939022 | |
| 10. | Даш Сүхбат | ШЖ67100375 | БӨ-уртын гол 8-57 | 99353815 | |
| 11. | Дүгэрсүрэн Бямбажав | ФВ75031517 | Жаргалант | 95551475 | |
| 12. | Пүрэв Ичинхорлоо | ФВ70121301 | БӨ-баянцагаан 7-18 | 88282651 | |
| 13. | Лхагвасүрэн Түвшинтөгс | ФА88073117 | БӨ-эрдэнэ 40-14 | 95000170 | |
| 14. | Магсар Батчулуун | ФА53071378 | БӨ-говил | 99808214 | |
| 15. | Дидарсангад Золжаргал | ТГ87051400 | БӨ-наран 65-03 | 95157578 | |
| 16. | Дэмбэрэл Алтантуяа | ФМ67100830 | БӨ-эрдэнэ6а-44 | 99764399 | |
| 17. | Ядамсүрэн Нанзаддорж | ИУ69091817 | БӨ-дэнж 2-4 | 99057244 | |
| 18. | Бөттөр Лхагвасүрэн | РЙ73101700 | БӨ-даваат17-7 | 99074639 | |
| 19. | Жанчивдорж Баярсайхан | ШЗ57110770 | БӨ-согоот 6-16-51 | 99352148 | |
| 20. | Эрдэнэбат Ганбаатар | Ф681121418 | БӨ-эрдэнэ баг | 99048693 | |
| 21. | Хишигбаяр Барсбаатар | ФВ75051910 | Жаргалант | 99692549 | |
| 22. | Рэнцэндолгор Долгормягмар | Фв61070129 | Жаргалант | 95226136 | |
| 23. | Баяраа Буяндэмбэрэл | фв88010914 | Жаргалант | 99304248 | |
| 24. | Дорж Урантөгс | ФВ67081600 | Жаргалант | 95555624 | |
| 25. | Цэдэвбазар Нарангэрэл | ФВ70010101 | Жаргалант | 99464227 | |
| 26. | Санжхүү .Нямаа | Ом66031411 | Жаргалант | 95368351 | |
| 27. | Бүдээ Бямбацэрэн | ПО72120201 | Жаргалант | 99264520 | |
| 28. | Бавуужав Батдорж | ФЖ89012015 | Жаргалант | 99555636 | |
| 29. | Дамдиндорж Батсугар | фв92050818 | Жаргалант | 99363782 | |
| 30. | Аюуш Сарантуяа | ФВ72022226 | Жаргалант | 99355443 | |
| 31. | Гэндэнсүрэн Шархүү | ФМ58021863 | БӨ-уртбулаг 5-17-48 | 99362103 | |
| 32. | Жаргал Оюунчимэг | ИЖ88072301 | БӨ-даваат 16-1620 | 99194489 | |
| 33. | Хишигбаяр Дүүрэнзаяа | ФМ76111461 | БӨ-хүрэнбулаг 4-22-4 | 99362140 | |
| 34. | Сандаг Мишиг | ФМ52070972 | БӨ-уртбулаг 5-1-76 | 99351256 | |
| 35. | Хансанжав Мөнхбаатар | ФБ80052815 | БӨ-шанд 27а-16 | 88122422 | |
| 36. | Ганболд Итгэл | МБ90042108 | БӨ-эрдэнэ чингэл 36-3 | 99967736 | |
| 37. | Гунгаа Сэлэнгэ | ИЦ71011064 | БӨ-булаг 15-3 | 99367256 | |
| 38. | Эрдэнэтийн шудрага ээд ТББ | 4419243 | БӨ-Зүүн дэнж | 99118547 | |
| 39. | Оргил Авирмэд | ФБ91101658 | БӨ-яргуйт овоот 18-11 | 99350343 | |
| 40. | Д.ШИНЭБААТАР | ВЮ7202266 | БӨ-эрдэнэ | 95340980 | |
| 41. | Баасансүрэн Алтанцэцэг | ФБ73122007 | БӨ-ц/чулуут7-4 | 95347782 | |
| 42. | Бямбасүрэн Болорцэцэг | ЛЮ82100863 | БӨ-оюут 1-6-29 | 94113442 | |
| 43. | Лундаа Лхамсүрэн | ФА63040166 | БӨ-уурхайчин 3-13-13 | 99351826 | |
| 44. | Жамбал Намсрай | ФБ68072603 | БӨ-уурхайчин 3-7-12 | 99355735 | |
| 45. | Дорж Болор-Эрдэнэ | ФБ71062317 | БӨ-ц/чулуут 53-12 | 99350123 | |
| 46. | Самдан Мягмарсүрэн | АИ77100400 | БӨ-баянцагаан | 86555313 | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 47. | Бат-Очир Баярсайхан | ЛБ87083113 | БӨ-эрдэнэ 52-17 | 88101219 |
| 48. | Гүнмэнд Жаргал | ИЦ41051303 | БӨ-рашаант 29-14 | 99551916 |
| 49. | Батбуян Хүслэн | ФБ00292640 | БӨ-эрдэнэ 23-26 | 80009336 |
| 50. | Мягмар Алтанцэцэг | ИЙ78010401 | БӨ-яргуйт толгод 31-7 | 99368039 |
| 51. | Адьяа Алтантуяа | ФВ65040106 | БӨ-булаг 4-10 | 99555426 |
| 52. | Элдэв-Очир Отгон-Эрдэнэ | ФН81080841 | БӨ-согоот 6-15-78 | 99355689 |
| 53. | Шарав Оюунжаргал | ИЙ66082403 | БӨ-шанд20-29 | 99651966 |
| 54. | Намжил Цэгмэд | ФВ74090411 | БӨ-уртын гол 5-12 | 95345817 |
| 55. | Дашханд Нарантуяа | ГЭ63032709 | БӨ-шанд 24-35 | 99555845 |
| 56. | Адьяа Баярсайхан | ЙР64040171 | Баян-Өндөр | 94913836 |
| 57. | Цэрэндорж Хишигжаргал | ФБ57082367 | Баян-Өндөр | 99925652 |
| 58. | Галсандорж Оюунтуяа | Г365071302 | БӨ-ц/чулуут | 99360213 |
| 59. | Адишаа Зул | МБ66122611 | БӨ-ц/чулуут | 95345192 |
| 60. | Алтансух Бадамсайн | АВ79092616 | БӨ-ц/чулуут 27а-18 | 99543949 |

ОЛГОСОН:

ХҮНС ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРЫН НЯРАВ Б.ЗОЛЖАРГАЛ

ХЯНАСАН:

АХЛАХ НЯГТЛАН БОДОГЧ О.ОЮУН-ЭРДЭНЭ

Хүлэмжийг хүлээлгэн өгөх актад Жаргалант сумын 10 иргэний батламж хавсаргасан, А.Сарантуяагийн батламж, Баян-Өндөр сумын 49 иргэний батламж байхгүй.




Баян-Өндөр сумын ЗДТГ-т 2024 оны 09 дүгээр сарын 19-ний өдөр гэрээг шалгахад эрх зүйн талаас гэрээ байгуулсан эрх бүхий этгээдийн гарын үсэг, тамга байхгүй, зөвхөн олгосон нярав гээд зарим гэрээнд гарын үсэг зураагүй, ашиглаж байгаа тал зураагүй, гарын үсгийн тайлал байхгүй, мөнгөн дүнг гэрээнд тусгаагүй, 2.5 дахь заалтад ашиглалтын хоног зарим гэрээнд байхгүй, 1 иргэн/Г.Батбуян/ -ийн баримт хоосон гэрээнд хавсаргасан, иргэний үнэмлэх, хүлэмж авахыг хүссэн өргөдөл баримт бичиг огт байхгүй 26 гэрээ хийгдсэн.

Санхүүгийн тайлангийн бүртгэл хөтлөлтийг үзэхэд 2022.06.07-нд бараа материалын тусгай зориулалтын хөрөнгөнд бүртгэн авч, Төрийн аудит, аймгийн ЗДТГ-ын Санхүү төрийн сангийн хэлтсийн баталсан 2022, 2023 оны Санхүүгийн тайланд дэлгэрэнгүй тодруулга хийгээгүй, мөнгөн дүнг тусгаагүй. 2024.06.21-ний өдөр бүртгэлээс хасалт хийсэн байна.

ӨМЧ ХАМГААЛАХ БАЙНГЫН ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2024.06.19 № 05 Баян-Өндөр сум

**Олон талт түншлэлийн хүрээнд "Үйлдвэрлэгч баг" төсөл Орхон аймаг Баян-Өндөр сум ХХААХҮЯ/202212056 дугаартай тендер Улсын төсвөөс санхүүжиж** Орхон аймагт 60 ширхэг хүлэмж ирснээс 49 ширхэг хүлэмжийг манай сум тусгай зориулалтын барааны орлогод бүртгэж авсан. 49 ширхэг хүлэмжийг иргэд, аж ахуйн нэгж байгууллагад 2022 оны 06 дугаар сард гэрээ байгуулж олгосон байна. Үүнтэй холбоотойгоор өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хурлаар шийдвэрлэх санал гаргаснаар 2024 оны 06-р сарын 19-ний өдрийн 09 цаг 30 минутад Баян-Өндөр сумын ЗДТГ-ын Иргэний танхимд хуралдав.

Хуралд:

| | |
|---|---|
| Өмч хамгаалах байнгын зөвлөлийн дарга: | Б.Ган-Эрдэнэ /оролцсон/ |
| Нарийн бичгийн дарга: | П.Даваажаргал /оролцсон/ |
| Гишүүд: | С.Сэрээтэрдорж /оролцоогүй/ |
| | А.Адьяадолжин /оролцсон/ |
| | А.Отгондарь /оролцсон/ |
| | А.Аззаяа /оролцсон/ |
| | Б.Делгеен/ оролцсон/ |

Хурлын ирц 90% хувьтай.

**Хэлэлцэх асуудал:** Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйл 31.1 Төрийн өмчит хуулийн этгээд эзэмшилдээ байгаа илүүдэл үндсэн эд хөрөнгө,түүнчлэн ашиглах хугацаа нь дууссан буюу эсхүл осол гэмтэлд өртсөний улмаас зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон бөгөөд засаж, сэлбэж ашиглах нь эдийн засгийн хувьд үр ашиггүй нь тооцоогоор нотлогдсон эд хөрөнгийг худалдаж, шилжүүлж, акт тогтоон устгаж болно гэсэн хуулийн заалтыг үндэслэл болгож гэрээний нөхцөлийн дагуу 49 хүлэмжийг данснаас хасах тухай.

**Б.Делгеен**: Та бүхэндээ энэ өдрийн мэнд хүргэе. Өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хурал эхэлж байна. 2022 оны 06 сарын 07-ны өдөр 49 ширхэг буюу 490,000,000 сая төгрөгийн хүлэмжийг тусгай зориулалтын барааны орлогод бүртгэсэн байна. Нийт 60 ширхэг хүлэмж олгосон жагсаалт, материал байгаа нь Жаргалант сумын 11 хүлэмжтэй нийлсэн байгаа. Холбогдох бичиг баримтуудтай гишүүд танилцаад саналаа хэлээд явъя.

**Б.Ган-Эрдэнэ**: Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн заалтад нийцэж байгаа тул татгалзах зүйлгүй дэмжиж байна.

**П.Даваажаргал:** Олон талт түншлэлийн хүрээнд "Үйлдвэрлэгч баг" төслийн хүрээнд 49 иргэнд олгосон хүлэмжийг байгууллагын тусгай зориулалтын бараанд бүртгэгдсэн. Актлах жилийн хугацаа дууссан тул иргэдэд бүрэн эзэмшүүлэх гэрээний нөхцөлийн дагуу данснаас хасах саналтай байна.

**А.Адьяадолжин**: Нэгэнт иргэдэд олгох нөхцөлтэйгөөр гэрээ хийгдэж, тараагдсан тул иргэдэд олгосон жагсаалт, өргөдлийг нотлох баримт болгоод актлах нь зөв гэж үзэж байна.

**А.Отгондарь:** Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 Аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг даргын тамгын газрын дарга, Засаг дэргэдэх газар, хэлтэс, албаны дарга эрх хэмжээний хүрээнд тушаал гаргаж, тогтоосон журмаар үйлдсэн тамга, тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйл 31.1 Төрийн өмчит хуулийн этгээд эзэмшилдээ байгаа илүүдэл үндсэн эд хөрөнгө,түүнчлэн ашиглах хугацаа нь дууссан буюу эсхүл осол гэмтэлд өртсөний улмаас зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон бөгөөд засаж, сэлбэж ашиглах нь эдийн засгийн хувьд үр ашиггүй нь тооцоогоор нотлогдсон эд хөрөнгийг худалдаж, шилжүүлж, акт тогтоон устгаж болно. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3.1 дэх заалт

худалдах, шилжүүлэх, устгах эд хөрөнгийн талаар өмч хамгаалах Байнгын зөвлөл дүгнэлт гаргасан байх гэсэн заалтуудыг үндэслэж тус саналыг 100% дэмжиж байна.

**Н.Аззаяа**: Бусад гишүүдийн хэлсэнтэй санал нэг байна. 100% дэмжиж байна.

**Шийдвэрлэсэн нь:**

Хуралд оролцсон гишүүдийн 100% -ийн саналаар 49 ширхэг буюу 490,000,000 сая төгрөгийн тусгай зориулалтын барааг иргэдэд бүрэн эзэмшүүлэх гэрээний нөхцөлийн дагуу данснаас хасахаар шийдвэрлэв.

Хурал: 10 цаг 30 минутад дуусав.

**Тэмдэглэл бичсэн:**

Нарийн бичгийн дарга: П.Даваажаргал

**Танилцаж зөвшөөрсөн:**

Зөвлөлийн дарга: Б.Ган-Эрдэнэ

Гишүүд: А.Адъяадолжин

А.Отгондарь

Н.Аззаяа

Б.Дөлгөөн

Данснаас хасалт хийхдээ Баян-Өндөр сумын өмч хамгаалах ажлын хэсэг хуралдаж, протокол үйлдээд, ЗДТГ-ын дарга тушаалаар шийдвэр гарган хасжээ. Энэхүү хүлэмж нь ХХААХҮЯ-аас шилжүүлсэн хөрөнгө бөгөөд ХХААХҮ-ийн салбарт мөрдөх Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг хөрөнгө данснаас хасах тухай:

“Актлах - Жилийн эцсийн тооллогын дараа Тооллогын комисс хөрөнгийн ашиглалтад үнэлгээ өгөх ба байгууллагын удирдлагад танилцуулж зөвшөөрөл авсны дараа актлах, устгах, худалдах хөрөнгийн жагсаалтыг эрх бүхий төрийн байгууллагын удирдлагын зөвлөлд танилцуулна. Эрх бүхий төрийн байгууллагаас хасагдах хөрөнгийн жагсаалтыг хянан үзэж шийдвэр гарсан үед үндсэн хөрөнгийг данснаас хасна.

УСНББОУС-17 дугаар стандартаар дахин ашиглах боломжтой ашиглах хугацаа дууссан хөрөнгүүдийг дахин үнэлгээ хийж орлогод авах, үндсэн хөрөнгөөс хангамжийн материал руу шилжүүлэхдээ байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөл нь үндсэн хөрөнгийн дахин үнэлгээ хийх, акталж данснаас хасах тухай саналыг бэлтгэж, байгууллагын удирдлагад танилцуулна. Улмаар үндсэн хөрөнгийн дахин үнэлгээ хийх, акталж данснаас хасах тухай асуудлыг боловсруулж холбогдох **эрх бүхий байгууллагуудад хүргүүлж шийдвэрлүүлнэ**” гэж заасан. Тус баримт бичигт Зоорь хүлэмж нь 15 жил элэгдэх хугацаатай байна гэж заасан бөгөөд Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31.1 дэх заалтыг “Төрийн өмчит хуулийн этгээд эзэмшилдээ байгаа илүүдэл үндсэн эд хөрөнгө, түүнчлэн ашиглах хугацаа нь дууссан буюу эсхүл осол гэмтэлд өртсөний улмаас зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон бөгөөд засаж, сэлбэж ашиглах нь эдийн засгийн хувьд үр ашиггүй

нь тооцоогоор нотлогдсон эд хөрөнгийг худалдаж, шилжүүлж, акт тогтоон устгаж болно" үндэслэн хасжээ. Хөрөнгийг хассан нь буруу бөгөөд:

1. Эдийн засгийн үр ашгийн тооцоо хийгдээгүй,
2. Хүлэмжийг данснаас хасах тухай холбогдох эрх бүхий байгууллагын зөвшөөрөл аваагүй
3. Жилийн эцсийн тооллогоор бус хагас жилийн тайлан балансаас хассан байна.



ОРХОН АЙМАГ
БАЯН-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2024 оны 06 сарын 19 өдөр    Дугаар А/74    Баян-Өндөр сум

Бараа материалыг данснаас хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйл 31.1, Байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн 2024 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн 04 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Данснаас хасалт хийх тусгай зориулалтын бараа материалыг хавсралтаар батлсугай.

2.Тусгай зориулалтын бараа материал болох 490,000,000 (дөрвөн зуун ерэн сая) төгрөгийн тусгай зориулалтын бараа материалыг данснаас хасалт хийхийг Нягтлан бодогч (А.Адьяадолжин)-д зөвшөөрсүгэй.

3.Тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Санхүүгийн албаны дарга (Б.Ган-Эрдэнэ)-д даалгасугай.

ДАРГА    Ш.ӨЛЗИЙБАЯР

6124030172

Жаргалант сумын ЗДТГ-т 2024.09.23-ны өдөр ажиллахад 11 гэрээ байхгүй 2022 оны санхүүгийн тайланд бараа материалын дэлгэрэнгүй тодруулга улсын төсвөөс тусгай бараа материалд хүлэмж гэж дурдсан ч мөнгөн дүнг тусгаагүй байна.

Нэмэлт дансанд Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс 345,604,8 мянган төгрөгийн санхүүжилт, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 198,816.1 мянган төгрөг дээд шатны төсвийн захирагчийн тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан санхүүжилт 1,600,0 мянган төгрөг нийт 546021,0 мянган төгрөгийн санхүүжилт хүлээн авч үйл ажиллагаа явуулсан бөгөөд 1-12 сарын үйл ажиллагааны гүйцэтгэлээр тайлагнасан байна.

2022 оны 12 сарын эцсээр нийт 101,446,1 мянган төгрөгийг төвлөрүүлэх шилжүүлэг хийсэн байна.

Хүснэгт . Санхүүгийн тайлангийн үзүүлэлт / төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 955,150.0 | 455,150.0 | 500,000.00 |
| Бараа материал | 195,609,600.00 | 828,153,123.00 | 632,543,523.00 |
| Үндсэн хөрөнгө | 4,784,679,350.42 | 5,840,227,579.66 | 1,055,548,229.24 |
| Авлага | 212,163,541.30 | 19,946,784.64 | -192,216,756.66 |
| Өр төлбөр | 40,535,207.24 | 19,946,784.64 | 20,288,422.60 |
| **Нийт хөрөнгө** | **5,223,407,641.72** | **6,778,662,637.30** | **1,539,621,252.24** |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **5,223,407,641.72** | **6,778,662,637.30** | **1,539,621,252.24** |

Хүснэгтийн тайлбар:

Мөнгөн хөрөнгө: ЗДТГ-ын ахмадын сангийн харилцах дансанд 455,1 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байгаа.

Бараа материал: Тусгай зориулалтын материал дансанд 2022 онд суманд дээд шатны байгууллагуудын хөрөнгө оруулалтаар хийгдсэн хүлэмж, Тэрбум мод хөтөлбөрийн хүрээнд хийгдсэн мод бут, мөн 1 жилээс дээш ашиглагдах материалын нийт 200 гаруй сая төгрөгийн орлого авагдаж, тусгай

2023 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн 23/03 дугаартай актаар 90ш хүлэмжийг хүлээн авсан, Хүлээлгэн өгсөн акт, иргэний үнэмлэх, хүсэлт байхгүй, 12 гэрээ хийгдээгүй, 4 иргэний регистр зөрүүтэй, Б.Бүдрагчаагийн гэрээнд хаяг, утас бичээгүй, гарын үсэг таталсан тайлалгүй. ШШГГазар-437 дугаар нээлттэй хорих анги гэрээнд регистр байхгүй, 2ш гэсэн боловч 1ш хүлэмжийн гэрээ хийсэн зөрчлүүд илэрлээ.

Үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийг гэрээгээр олгохдоо иргэний үнэмлэхийг заримыг хавсаргаад, зарим иргэдийн иргэний үнэмлэх дутуу, ХААМСҮТ-ийн албан тоот, гэрчилгээ байхгүй, баримт бүрдүүлэлт хангалтгүй байна. Хандсүрэн, Оюун-

Эрдэнэ нарын гарын үсэгтэй, Хилийн цэргийн 0286-р ангид 2ш хүлэмжийн гэрээг хийж олгосон зөрчлүүд байна.

2023 оны 05 дугаар сарын 13-ны 23/06 дугаар 570,000,000 төгрөгийн үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж, газар тариалангийн зориулалттай техник хэрэгслийг тус тус хүлээн авсан байна. /Сэхүүн чоно ХХК-тай 2022 онд хийсэн гэрээний үлдэгдэл/ 23/06 дугаар бүхий хөрөнгө хүлээн авах актад хүлээлгэн өгсөн хүний гарын үсэг байхгүй./Сэхүүн чоно ХХК-ийн захирал н.Тэгшжаргал/

Тоног төхөөрөмж эзэмших гэрээг компаниар хийгээд бүртгэлд иргэнээр бүртгэсэн, иргэний гарын үсэг таталдсан, нэр байхгүй /гарын үсэг тайлалгүй/ тул гэрээний эрх зүйн талаас учир дутагдалтай. Б.Сайнжаргалын Иргэний үнэмлэх хавсаргаагүй, Арвин сүрэг хоршоо, Нүүдэлчин мон агро ХХК-ийн гэрчилгээ байхгүй, мах бэлтгэх тоног төхөөрөмж хүлээлгэн өгсөн актад огноо, нэр байхгүй, 2024 оны сонгон шалгаруулалтын ажлын хэсгийн хурлын тэмдэглэлд нягтлан бодогчийн гарын үсэг дутуу.

Санхүүгийн бүртгэл хөтлөлтийн байдал тухайн байгууллагын санхүүгийн ажилтны ур чадвараас хамаарч харилцан адилгүй байна. ХХААГ-ын 2022 оны санхүүгийн байдлын тайланд бараа материалыг НББОУС-ын дагуу бүртгэж, тодруулгыг ойлгомжтой тайлагнасан бол 2023 оны санхүүгийн байдлын тодруулга хангалтгүй байна. Жаргалант сумын ЗДТГ-ын 2022 оны санхүүгийн тайланд тусгаж, тодруулгад дурдсан ч мөнгөн дүнг тусгаагүй, анхан шатны баримт байхгүй, Баян-Өндөр сумын ЗДТГ-ын санхүүгийн байдлын тайланд бүртгэл хөтлөлтийг хийж тодруулгын тайлан байхгүй, эрх бүхий этгээдээс зөвшөөрөл авалгүй, эдийн засгийн үр ашгийн тооцоолол хийлгүй, хагас жилийн балансд хасалт хийсэн зэрэг зөрчлүүд байна.

**2.4 Ил тод байдал хангалтгүй байна.**

**2.4.1 Шинэ хөдөө төслийн ил тод байдал хангалтгүй байгаагаас төсөл ирүүлээгүй аж ахуйн нэгж байгууллагууд тоног төхөөрөмжийн хөнгөлөлтөд хамрагдаж сонгон шалгаруулах ажлын хэсэг байгуулж ажиллуулсан үр дүнгүй байна.**

ХХААГ-ын даргын 2024.05.22 өдрийн А/14 тоот тушаалаар нийлүүлэгдсэн тоног төхөөрөмжийг гэрээгээр эзэмших, ашиглах иргэн, аж ахуйн нэгжийг сонгон шалгаруулах ажлын хэсгийг байгуулж, Цагаан идээ боловсруулах үйлдвэрийн тоног төхөөрөмж 4 төрлөөр тус бүр 2, нийт 8 тоног төхөөрөмж ирсэн. Иргэдэд зар хүргэхдээ:

- 5-350 миллилитрээр шингэн хүнс савлах төхөөрөмж 1ш
- Вакумдах суурь машин 1ш
- Автомат савлагааны машин 1ш
- Хаяг, шошго хэвлэх бүрэн автомат машин 2ш гэж зарыг тавьсан байна.

Тус ажлын хэсэг 2024.05.27-ны өдөр хуралдаж, 2 иргэн, 2 аж ахуйн нэгж материал ирүүлснээс 2 иргэн, 1 аж ахуйн нэгж хуралд танилцуулгаа хийжээ. Иргэн

Баярсайханд шингэн хүнс савлах төхөөрөмж, Д.Даваасүрэнд вакумдах суурь машин, Баярмөнх-Наран ХХК-д хаяг, шошго хэвлэх машин олгох шийдвэр гаргажээ.

Тус тоног төхөөрөмжийг олгосон гэрээг

1. 2023.11.01-ний өдөр Баяжуулагч одод ХХК-тай "**Автомат савлагааны**" тоног төхөөрөмж ашиглуулах гэрээ байгуулж, Ивээлт сүү ХХК-тай хүлээлцэх акт үйлдсэн. /Аж ахуйн нэгжийн гэрээ байхгүй/
2. 2023.11.01-ний өдөр Баяжуулагч одод ХХК-тай "**Шингэн савлах"** тоног төхөөрөмж ашиглуулах гэрээ байгуулж, Ивээлт сүү ХХК-тай хүлээлцэх акт үйлдсэн. /Аж ахуйн нэгжийн гэрээ байхгүй/
3. 2023.11.01-ний өдөр Хос луу баян ХХК-тай "**Ваакумдах суурь машин**" тоног төхөөрөмж ашиглуулах гэрээ байгуулж, хүлээлцэх акт үйлдсэн.
4. 2024.06.06-ны өдөр Баяр мөнх наран ХХК-тай **"Савлагааны бүрэн автомат машин"** тоног төхөөрөмж ашиглуулах гэрээ байгуулж, актаар хүлээлгэн өгсөн.
5. 2024.06.06-ны өдөр иргэн Б.Баярсайхантай "**Шингэн савлах"** тоног төхөөрөмж ашиглуулах гэрээ байгуулж, актаар хүлээлгэн өгсөн.
6. 2024.06.06-ны өдөр иргэн Д.Даваасүрэнтэй "**Ваакумдах суурь машин**" тоног төхөөрөмж ашиглуулах гэрээ байгуулж, актаар хүлээлгэн өгсөн.

Автомат савлагааны болон Савлагааны бүрэн автомат машин олгогдоогүй байна. Дээрх Баяжуулагч одод, Хос луу баян ХХК-ууд нь төсөл сонгон шалгаруулахад материал ирүүлээгүй, хамрагдсан байна.

## Цагаан идээ боловсруулах үйлдвэрийн тоног төхөөрөмж

2023.11.01

| № | Гэрээ байгуулсан болон олгосон огноо | Нэрс | Сум | Тоног төхөөрөмжийн нэр | Үнийн дүн |
|---|---|---|---|---|---|
| 1. | 2023.11.01 | Баяжуулагч одод ХХК | Баян-Өндөр | Автомат савлагааны машин | 56,784,000 |
| 2. | 2023.11.01 | Баяжуулагч одод ХХК | Баян-Өндөр | Шингэн савлах | 7,200,000 |
| 3. | 2023.11.01 | Хос луу баян ХХК | Баян-Өндөр | Вакумдах суурь машин | 5,650,000 |
| 4. | 2024.06.06 | Баяр мөнх наран ХХК | Баян-Өндөр | Савлагааны бүрэн автомат машин | 48,685,000 |
| 5. | 2024.06.06 | Б.Баярсайхан | Баян-Өндөр | Шингэн савлах төхөөрөмж 350 мл | 7,200,000 |
| 6. | 2024.06.06 | Д.Даваасүрэн | Баян-Өндөр | Вакумдах суурь машин | 5,650,000 |
| 7. | Олгогдоогүй, гэрээ байхгүй | | | | 48,685,000 |
| 8. | | | | | 56,784,000 |
| **Нийт дүн** | | | **236,638,000** | | |

### 2.4.2 Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээлсэн байдал.

2022 оны шилэн дансны мэдээлэл систем шинэчлэгдсэний улмаас харах эрхгүй, 2023 онд мэдээллийг оруулаагүй, оруулах мэдээлэл байхгүй сонголтоор хаасан, 2024 онд Хөрөнгө оруулалт, тендер худалдан авалт бүлгийн Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэлд ил тод мэдээлж ажиллажээ.

| Үзүүлэлт | Эхлэх огноо | Дуусах огноо | Төсөвт өртөг | Гэрээний дүн | Тухайн жилийн | Тухайн жилийн | Үүсгэсэн огноо |
|---|---|---|---|---|---|---|---|
| "Шинэ хөдөө-Тогтвортой хөгжил" төслийн тоног төхөөрөмж /Орхон, Жаргалант сум/ багц-4 дотоодод үйлдвэрлэсэн мал эмнэлгийн лабораторын шинжилгээний оношлуур худалдан авах гэрээ №ХХААХҮЯ/20240102013 | 2024-04-03 | 2024-05-30 | 110,000,000 | 110,000,000 | 110,000,000 | 110,000,000 | 2024-07-03 |
| "Шинэ хөдөө-Тогтвортой хөгжил" төслийн тоног төхөөрөмж /Орхон, Жаргалант сум/ багц-3 мал эмнэлгийн лабораторын шинжилгээний оношлуур худалдан авах гэрээ №ХХААХҮЯ/20240102013 | 2024-04-03 | 2024-05-30 | 70,059,000 | 70,059,000 | 70,059,000 | 70,059,000 | 2024-07-03 |
| "Шинэ хөдөө-Тогтвортой хөгжил" төслийн тоног төхөөрөмж /Орхон, Жаргалант сум/ багц-2 лабораторын тоног төхөөрөмж худалдан авах гэрээ №ХХААХҮЯ/20240102013 | 2024-04-04 | 2024-05-04 | 72,820,000 | 72,820,000 | 72,820,000 | 72,820,000 | 2024-07-03 |
| "Шинэ хөдөө хүлэмж" төслийн тоног төхөөрөмж /Орхон, Жаргалант сум/ худалдан авах гэрээ №УТ2401900399 | 2024-04-04 | 2024-05-04 | 492,500,000 | 492,500,000 | 492,500,000 | 492,500,000 | 2024-07-03 |
| "Шинэ хөдөө-Тогтвортой хөгжил" төслийн тоног төхөөрөмж /Орхон, Жаргалант сум/ багц-1 трактор худалдан авах гэрээ №ХХААХҮЯ20240102013 | 2024-04-27 | 2024-05-27 | 188,475,000 | 188,475,000 | 188,475,000 | 188,475,000 | 2024-07-03 |
| "Шинэ хөдөө-үйлдвэрлэгч өрх" төслийн тоног төхөөрөмж /Орхон, Жаргалант сум/ худалдан авах гэрээ №ХХААХҮЯ/20240102015 | 2024-04-16 | 2024-06-16 | 467,409,600 | 467,409,600 | 467,409,600 | 467,409,600 | 2024-07-03 |

## 2.5 Шинэ хөдөө төслийн тоног төхөөрөмжийг эзэмшүүлэх сонгон шалгаруулалтын үйл ажиллагаа хангалтгүй байна.

### 2.5.1 Сонгон шалгаруулалтыг хугацаа алдаж зохион байгуулсан, сонгон шалгаруулалтын процесс алдагдсан байна.

Тус тоног төхөөрөмжийг 2023 оны 06 дугаар сарын 22-ны өдөр 230505/05-290 дугаар актаар барааг хүлээн авч, ХХААГ-ын даргын 2024 оны 03 дугаар сарын 26-ны А/09 дугаар тушаалаар иргэн, аж ахуйн нэгжийг сонгон шалгаруулах ажлын хэсэг байгуулагдаж, 2024 оны 04 дүгээр сарын 27-ны өдөр тус ажлын хэсэг хуралдаж иргэн, аж ахуйн нэгжийг сонгожээ. Тоног төхөөрөмжийн олголтын явц удаашралтай, хурлын тэмдэглэлд нягтлан бодогчийн гарын үсэг дутуу. Г.Ганбаатарын гэрээг 2024.05.10-ны өдөр байгуулж, бараа материалыг 2023.09.05-ны өдөр актаар хүлээлцсэн. Бусад иргэдтэй 2024.05.10-нд хүлээлцсэн байна. Хүмүүсээ сонгож, тоног төхөөрөмжөө хүлээлцсэний дараа хурал хийж, гэрээ байгуулж шалгаруулах процессын дэс дараалал алдагдуулсан байна.

# Бараа материал хүлээлцсэн акт

.алаас Орхон аймгийн Хүнс,хөдөө аж ахуйн газрын нярав Б.Золжаргал (цаашид
гэх) нөгөө талаас Орхон аймгийн ...Баян-Өндөр...сумын .......Т.Ганбаатар.
д ашиглагч гэх) нар 2023 оны.09.дугаар сарын..05-ны өдөр дор дурьдсан бараа
иалыг хүлээлгэн өгч акт үйлдэв.

1.Бороожуулагч усалгааны төхөөрөмж /иж бүрдэл/

| | Эд анги | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | Эд ангийн үзүүлэлт |
|---|---|---|---|---|
| 1 | Төв шугам | ш | 20 ✓ | 110 мм, 5 м урт |
| 2 | Салбар хоолой | ш | 190 ✓ | 50 мм, 5 м урт |
| 3 | Бороожуулагчийн суурь | ш | 100 ✓ | 32 мм |
| 4 | Бороожуулагчийн тулгуур | ш | 100 ✓ | 32 мм*80 см |
| 5 | Бороожуулагчийн хаалт | ш | 100 ✓ | 50 мм |
| 6 | Бороожуулагчийн тулгуурийн шилжүүлэгч | ш | 100 ✓ | 32 м |
| 7 | Бороозуулагч толгой | ш | 100 ✓ | |
| 8 | Тройник | ш | 10 ✓ | 110*50*110 мм |
| 9 | Салбар шугамын хаалт | ш | 10 ✓ | 50 мм |
| 10 | Төгсгөгч таг | ш | 1 | 50 мм |
| 11 | Төгсгөгч таг | ш | 1 | 110 мм |
| 12 | Багасган шилжүүлэгч | ш | 1 | 110*75 мм |
| 13 | Усны насосны шилжүүлэг | ш | 1 | 75 мм |
| 14 | Усны насос | ш | 1 | 75 мм |
| 15 | Сорох хоолой | ш | 8 | 75 мм |
| 16 | L булан | ш | 2 | |

Сальник - Том 20
- Жижиг 3б.

Хүлээлгэн өгсөн:
ХХААГазрын нярав [signature] Б.Золжаргал

Хүлээн авсан:
Иргэн [signature] Т.Ганбаатар
Утас: 94117373

# ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ ҮНЭ ТӨЛБӨРГҮЙ АШИГЛУУЛАХ ГЭРЭЭ

2024 он 05 сар 10 өдөр №01 Орхон аймаг

## НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1 Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсэг, Иргэний хуулийн 189 дүгээр зүйлийн 189.1 дэх хэсэг, 340 дугаар зүйлийн 340.1.1, 340.1.3 дахь заалт, 341 дүгээр зүйлийн 341.1.1, 341.1.4 дахь заалт, 341.2 дахь хэсэг, 342 дугаар зүйлийг тус тус үндэслэн нэг талаас Орхон аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар (цаашид "эзэмшигч тал" гэх), нөгөө талаас ***Ганхуяг*** овогтой ***Ганбаатар (РД:РХ72051711)*** (цаашид "ашиглагч тал" гэх) нар нь дараах зүйлийг харилцан тохиролцож энэхүү гэрээг (цаашид "гэрээ" гэх) байгуулав.

## ХОЁР. ГЭРЭЭНИЙ АГУУЛГА

2.1 "***Шинэ хөдөө***" төслийн хүрээнд шинээр үйлдвэрлэл эрхлэх, үйлдвэрлэлээ өргөжүүлэх хүсэлтэй иргэнийг тоног төхөөрөмжөөр хангаж, үйл ажиллагааг тогтворжуулах зорилготой.

2.2 Гэрээний зүйл болох ***"Усалгааны бороожуулах" үйлдвэрлэлийн*** зориулалтаар ашиглана. нэр бүхий тоног төхөөрөмжийг

2.3 Энэхүү гэрээний ашиглагч тал нь аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар болон Улсын Их Хурлын гишүүн С.Ганбаатарын ажлын албаны сонгон шалгаруулалтаар шалгарсан иргэн байна.

2.4 Энэ гэрээний зүйл болох тоног төхөөрөмж нь Орхон аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын өмч байна.

2.5 Эзэмшигч тал нь ашиглагч талтай гэрээ байгуулсан өдрөөс хойш 5 хоногийн дотор тоног төхөөрөмжийг үнэ төлбөргүйгээр ашиглагч талд хүлээлгэн өгнө.

## ГУРАВ. ХУГАЦАА

3.1 Тоног төхөөрөмж ашиглалтын хугацаа.

3.1.1. эзэмшигч тал нь ашиглагч талд тоног төхөөрөмжийг хүлээлгэн өгөх, хүлээн авах актанд гарын үсэг зурсан өдрөөс эхлэн ашиглалтын хугацааг тоолно.

3.1.2 гэрээний үүргийн биелэлтийг гэрээ байгуулсан өдрөөс эхлэн тооцож, 2 жил тутамд дүгнэж, сунгалт хийх эсвэл гэрээг цуцлах эсэх асуудлыг Хүнс, хөдөө аж ахуйн газрын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хурлын шийдвэрийг үндэслэн шийдвэрлэнэ.

3.1.3 тоног төхөөрөмж нь ***14,985,000 (арван дөрвөн сая есөн зуун наян таван мянга)*** төгрөгийн үнэ бүхий бөгөөд хөдлөх хөрөнгийн ашиглалтын хугацааг тооцон, холбогдох тушаал, шийдвэрийг үндэслэн ашиглагч талд үнэ төлбөргүй шилжүүлэх асуудлыг шийдвэрлэж болно.

## ДӨРӨВ. ТАЛУУДЫН ЭРХ, ҮҮРЭГ

4.1. Эзэмшигч талын эрх, үүрэг:

4.1.1 эзэмшигч тал ашиглагч талд чанарын болон техникийн шаардлага, тоо хэмжээ, иж бүрдэл бүрэн тоног төхөөрөмжийг нийлүүлэх бөгөөд акт үйлдэн хүлээлгэн өгнө. Энэхүү акт нь гэрээний салшгүй хэсэг мөн.

4.1.2. тоног төхөөрөмжийг зориулалтын дагуу ашиглаж буй эсэхэд Хүнс, хөдөө аж ахуйн газрын өмч хамгаалах Байнгын зөвлөл хяналт тавьна.

4.1.3. гэрээний хүрээнд ашиглагч талаас тоног төхөөрөмжийн ашиглалтын тайлан мэдээг жил бүрийн 11 дүгээр сард хүлээн авч, холбогдох газарт тайлагнана.

4.1.4. гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг ашиглагч талаас шаардах эрхтэй.

Эзэмшигч талыг төлөөлж:

Ашиглагч талыг төлөөлж:

**2.5.2 Сонгон шалгаруулалтаар 1 аж ахуйн нэгжид олон тоног төхөөрөмж олгох, гадны аймгаас хамрагдах зэргээр аймгийн жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн боломж, хүртээмжид сөргөөр нөлөөлж байна.**

Баяжуулагч одод ХХК-д автомат савлагааны машин, шингэн савлах 2 ширхэг тоног төхөөрөмж, Эрдэнэтийн шударга ээзэд ТББ 10 ширхэг хүлэмж, ШШГГ-т 2ш хүлэмж, 2023 оны 90 ширхэг хүлэмжээс Хандсүрэн, Оюун-Эрдэнэ нарын гарын үсэгтэй, Хилийн цэргийн 0286-р ангид 2ш хүлэмжийн гэрээг хийж олгосон зөрчлүүд байна.

**2.6 Төслийн явц, хэрэгжилтийн байдал, ашиглалтын байдалд дүн шинжилгээ хийхэд 25 хувь нь ашиглаагүй. Энэ нь сонгон шалгаруулалтын шийдвэр оновчгүй байгааг харуулж байна.**

**2.6.1 Үйлдвэрлэгч баг, Шинэ хөдөө төслийн хэрэгжилтийн байдал, зарим тоног төхөөрөмж олгогдож, гэрээ байгуулагдаагүй байна.**

2022.07.29-ний өдөр Үйлдвэрлэгч баг төслийн 400,000,000 төгрөгийн тоног төхөөрөмж актаар /дугааргүй/ хүлээлцсэн.

ГУРАВ.ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН МЭДЭЭЛЭЛ

| Д/Д | Нэр төрөл | Марк | Үйлдвэрлэсэн улс, байгууллага, Огноо | Хэмжих нэгж | Тоо ширхэг | Нэг бүрийн үнэ | Нийт үнэ |
|---|---|---|---|---|---|---|---|
